

Гурав. Эрх зүйн үндэслэл:

Эрүүл мэндийн сайдын “Түр заавар батлах тухай” 2020 оны а/135 тушаал, “ Заавар батлах тухай” 2019 оны а/ 537 тушаал, “ Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай” 2017 оны а/505 тушаал, “ Заавар батлах тухай” 2017оны а/160 тушаал, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын “Заавар батлах тухай” 2020 оны а/15 тушаалуудыг үндэслэв.

Дөрөв. Үйлчлэх хүрээ:

Энэхүү түр зааврыг тусгаарлан ажиглах байранд, тухайн хугацаанд мөрдөх бөгөөд уг үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн бичиг баримт шинээр батлагдах, ДЭМБ-аас шинээр зөвлөмж ирсэн тохиолдолд хүчингүй болно. Мөн шинээр үүссэн нөхцөл байдалтай уялдуулан тухай бүр нэмэлт оруулахыг хичээх болно.

Тусгаарлан ажиглалтын үйл ажиллагааны зохион байгуулалт, дэс дараалал**Нэг. Үйлчлүүлэгчийг хүлээн авахад анхаарах асуудал:**

- Тусгаарлан ажиглах байранд мөрдөх дэг журам, халдвараас хамгаалах дэглэм, мэдээлэл дамжуулах урсгалыг танилцуулах
- Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдлын талаар тодорхой асуумж, мэдээлэл авах /архаг хууч өвчтэй эсэх, ялангуяа амьсгалын болон зүрх судасны эрхтэн системийн эмгэгийг анхаарах/
- Хэрвээ үйлчлүүлэгч өдөр тутам эм хэрэглэдэг бол өөрт байгаа эм нь тусгаарлан ажиглалтын хугацаанд хүрэлцэх эсэхийг тодруулах
- Зайлшгүй шаардлагатай тохиолдолд холбоо барих хүний утасны дугаарыг бүртгэлд заавал бичих

Хоёр. Үйлчлүүлэгчийн үүрэг:

- ЭМА-ы зөвлөгөө, зөвлөмжийг мөрдөх
- Өрөөний хаалгыг байнга хаалттай байлгах, өрөөний цонхыг 2 цаг тутамд нээж агаар сэлгэх
- Халуурсан, өвчний шинж тэмдэг илэрсэн бол нуулгүй, цаг алдалгүй эрүүл мэндийн ажилтанд мэдээлэх
- Гараа тогтмол угаах, амны хаалт зүүх
- Гар ариутгагч хэрэглэх
- Хэрвээ өдөр тутам хэрэглэдэг эм дуусч байгаа бол 3-аас доошгүй хоногийн өмнө ЭМА-д мэдэгдэх
- Хүүхэдтэй бол хүүхдийн эрүүл мэндийн байдалд хяналт тавих, өвчлөлөөс сэргийлэх
- Биеийн халуун, халдварын шинж тэмдгийн талаар тогтоосон цагт мэдээлэл өгөх

Гурав. Үйлчлүүлэгчийг байрлуулахад анхаарах нь:

- Үйлчлүүлэгчийг ирсэн өдрөөр нь, аль улсаас ирснээр нь
- Хүйсээр нь
- Гэр бүлээр нь байрлуулах
- Байнгын асаргаанд байдаг үйлчлүүлэгчийг асран хамгаалагчийн хамт байлгах

Дөрөв. Тусгаарлан ажиглах байранд хориглох үйл ажиллагаа:

- Гадны хүн оруулах
- Хоол хүнс зөөх
- Эргэлт оруулах
- Өрөө хооронд сэлгүүцэх
- Бөөнөөрөө нэг дор цугларах
- Зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хонгилд гарахгүй байх

Тав. Халдварын шинж тэмдэгийн тандалт хийж, биеийн халууныг хянах

- Үйлчлүүлэгчийн биеийн халууныг өдөрт 2 удаа үзэж тэмдэглэл хөтлөх
- Биеийн халууныг аль болох үйлчлүүлэгчийн өрөөгөөр орохгүй байхаар утсаар, эсвэл хаалганы гадна, дотор талаас ярилцах байдлаар авах
- Биеийн халууныг зайнаас халуун хэмжигчээр хэмжих / хэмжилт зөв эсэхийг байнга анхаар/
- Хуурай ханиалгах, булчин сулрах, булчингаар өвдөх, хамар битүүрэх, хоолой өвдөх, гүйлгэх шинж тэмдэг илэрсэн эсэхийг лавлах
- Биеийн халуун, халдварын шинж тэмдгийн тандалтыг их эмч, сувилагч хийж тэмдэглэл бүртгэл хөтлөх
- Халуураагүй өгүүлэмжтэй үйлчлүүлэгчтэй харьцахдаа нэг удаагийн халад, амны хаалт, бээлий өмсөх
- Эмч дуудах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд үйлчлүүлэгч өрөөнөөс гарахдаа амны хаалт заавал зүүх, амны хаалтыг зөв зүүсэн байхыг зөвлөх
- Амны хаалтын хангамжийг судлан, амны хаалтаар тасралтгүй хангах арга хэмжээ авах

Зургаа. Тусгаарлан ажиглах байранд хийгдэх цэвэрлэгээ, халдваргүйтгэл

- Цэвэрлэгээ хийхдээ ЭМС-ын 2019 оны а/537 тушаалын 6-р хавсралтыг мөрдөх
- Үйлчлэгч ажлын хувцасны гадуур нэг удаагийн халад өмсөж, ажлын дараа тайлж, устгах, амны хаалт, ахуйн бээлий, малгайг бүрэн эмсөх нь чухал
- Цэвэрлэгээ халдваргүйтгэлд шаардагдах хэрэглэгдхүүнээр бүрэн хангах
- Үйлчлүүлэгчийн өрөөнд өдөрт 2-оос доошгүй удаа чийгтэй цэвэрлэгээ хийх
- Цэвэрлэгээнд хэрэглэх материалыг өнгөөр ялгаж хэрэглэх
- Үйлчлүүлэгчийн нэг өрөөнөөс нөгөө өрөөнд шилжиж цэвэрлэхдээ цэвэрлэгээний уусмалыг сольж, алчуурыг халдваргүйжүүлэх
- Нэг өрөөг бүрэн цэвэрлэсний дараа нөгөө өрөөнд шилжих
- Хүний гар хүрэх бүх хатуу гадаргууг жавелионы 0,015%-ийн уусмалаар арчих
- Угаалгын өрөөний тосгуур, суултуурыг 0,03%-ийн уусмалаар арчих
- Үйлчлүүлэгчийн өрөөнд шүршиж халдваргүйтгэх аргаас аль болох татгалзах
- Хүүхэдтэй үйлчлүүлэгчид тоглоомыг угаах, халдваргүйжүүлэх бололцоог бүрдүүлэх, зөвлөх / 2% содын уусмалд буцалгах, спиртэн суурьт гар ариутгагчаар арчих/
- Халдваргүйжүүлэх уусмалыг өдөр бүр шинээр найруулж хэрэглэх
- Үйлчлүүлэгчийн өрөөнөөс гарсан хог хаягдлыг ЭМС-ын 2017 оны а/505 тушаалын дагуу цуглуулан, битүү тагтай саванд хийж дээрээс нь гипохлорид кальцийг жигд цацаж халдваргүйжүүлэх, шатаах

Долоо. Хооллолтод анхаарах нь:

- Хоолны зааланд бөөгнүүлж хооллохгүй
- Хоолыг үйлчлүүлэгчийн өрөөний хаалганы дэргэд тавих, аяга тавгаа мөн байдлаар эргүүлж авахаар зохицуулах
- Аяга, тавгаа авсан даруйдаа халдваргүйжүүлэх уусмал / сода 2%- д булхуулан, 30 минут буцалгах
- Аль болох нэг удаагийн хэрэгсэл ашиглахыг хичээх
- Хоолны хэрэгсэл, үлдэгдлийг ЭМС-ын 2017 оны а/505 тушаалын дагуу цуглуулан, битүү тагтай саванд хийж дээрээс нь гипохлорид кальцийг жигд цацаж халдваргүйжүүлэх, шатаах

Найм. Шинэ коронавирусийн халдварын шинж тэмдэгтэй, халуурсан үйлчлүүлэгч илэрсэн үед хэрэгжүүлэх арга хэмжээ буюу эрүүл мэндийн ажилтнуудын анхаарах асуудал:

- Сандрахгүй, үймж шуугихгүй, аль болох тайван байх
- Халуурсан, өвчний шинж тэмдэг илэрсэн үйлчлүүлэгчийн тухай бусад үйлчлүүлэгчид, ар гэрийнхэнд мэдэгдэхгүй байх / Энэ асуудлыг шуурхай багийн гишүүд хэрэгжүүлэх /
- Тусгаарлан ажиглах байранд ажиллаж буй ЭМА- нь ар гэрийнхэндээ мэдэгдэхгүй, сандралд оруулахгүй байхыг эрмэлзэх
- Биеийн халуун, илэрсэн шинж тэмдэг, хугацаа зэргийг дахин тодруулах
- Үйлчлүүлэгч өөрөө энэ талаар хаалганы дотноос гадагш хэлэх боломжгүй бол их эмч өрөөнд орж үзлэг хийх
- Олон ЭМА-г ойрын хавьтал болохоос сэргийлж, эмч бүх тусламж үйлчилгээ, тандалтыг явуулах чадварыг эзэмших
- Сэжигтэй үйлчлүүлэгчид үзлэг хийхдээ хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн өмсөх
- Сэжигтэй үйлчлүүлэгчийг үзсэний дараа биеийн байдал, илэрч буй шинж тэмдэг, тархвар зүйн асуумжаар тодруулсан мэдээллийг сувилагч, тархвар судлагчид утсаар, эсвэл өрөөний дотор талаас гадагш нь ярилцах байдлаар дамжуулах
- Мэдээллийг авсан ЭМА үйлчлүүлэгчийг халдварын сэжигтэй гэж үзвэл ЭМГ-ын хариуцлагатай жижүүрийн 70272225 утсаар яаралтай мэдээлэх
- Үйлчлүүлэгчид нэн яаралтай эмчилгээ хийх шаардлагатай бол үзлэг хийсэн эмч эхний эмчилгээг хийх
- Шаардлагатай эм, тариа эмнэлгийн хэрэгслийг хаалганы гадна тавиулж, гадна байгаа ЭМА-г холдсоны дараа шагайж авах г.м дэглэм баримтална.
- Нэг өрөөнд байгаа үйлчлүүлэгчид байдлыг товч танилцуулан, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, тэдний эрүүл мэндийн байдлыг хянах
- Нэг орсон ЭМА нь дээрх асуудлыг анхаарч, бүрэн гүйцэд хэрэгжүүлтэл, хувийн хамгаалах хувцас хэрэглэл ажиллах хугацаа /2 цагаас- 2цаг 30 минут байх/ дуустал үйлчлүүлэгчийг орхиж гарахгүй байх нь зүйтэй.
- Үйлчлүүлэгчийн өрөөнөөс гарахдаа хонгилд хамгаалах хувцасыг тайлж, халдваргүйжүүлэхээр зохицуулах/ комбинзон, малгай, амны хаалтыг хийсэн хог хаягдлын уутны амсарыг битүүмжилж үлдээх/

- Халдваргүйжүүлэх уусмалыг бэлтгэх, хог хаягдлын уут савыг байршуулахад анхаарах
- Хэрвээ сэжигтэй үйлчлүүлэгчийн өрөөнд гар утастай орсон бол утсаа 76%-ийн спирттэй бөмбөлгөөр гадаргууг нь сайтар арчих

Тусгаарлан ажиглах байранд ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны нэг өдөрт гүйцэтгэсэн ажлын тайлан, мэдээллийг тархвар судлагч эмч нэгтгэн, холбогдох албан тушаалтанд хүргүүлнэ.

Тусгаарлан ажиглах байранд байгаа үйлчлүүлэгчдэд ариун цэврийн хэрэглэл / оо, саван, сойз, ОО-цаас, нойтон сальфетка, эмэгтэйчүүдийн хэрэглэл г.м/, амны хаалт, гар ариутгагч санитол, сонин сэтгүүл, утасны нэгж, байнга хэрэглэдэг эм зэргийг захиалгын дагуу худалдаалах хангах ажиллагааг зохион байгуулна.

Тус байранд дайчлагдан ажиллах “тушаал шийдвэрээр томилогдсон” эрүүл мэндийн ажилтнуудыг дадлагажуулах сургалтад хамруулсан байна.

Тусгаарлагдан ажиглалтад байгаа үйлчлүүлэгчээс корона вирусийн сэжигтэй тохиолдол илэрсэн үед цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл дарааллыг шуурхай арга хэмжээний баг газар дээр нь очиж тогтооно.

БОЛОВСРУУЛСАН:

ЗХӨТСТ-ИЙН ДАРГА  Ж.АЛТАНЦЭЦЭГ